ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ҮЕНЧ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Аудитын код: ХОА-2021/46/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Утас: 70432545
цахим хаяг: Tunkhtulga.d@audit.gov.mn

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| *АДБОУС* | *Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт* |
| *АОУС* | *Аудитын Олон Улсын Стандарт* |
| *УСНББОУС* | *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* |
| *ТТЗ* | *Төсвийн төвлөрүүлэн захирагч* |
| *ТШЗ* | *Төсвийн шууд захирагч* |
| *ЗДТГ* | *Засаг даргын дамгын газар* |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

## Агуулга


1.Хараат бус аудиторын дүгнэлт....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....9

3. Аудитын тайлан....10

3.1. Ерөнхий зүйл....10

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....10

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....10

3.4. Материаллаг байдал....11

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....11

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....12

3.7. Шилэн дансны мэдээлэл....14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14

3.9. Аудитын илрүүлэлт....14

Залруулсан алдаа....14

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .. **Error! Bookmark not defined.**

Аудитын зөвлөмж....14

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....14

4. Менежментийн захидал....14

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....15

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.01.25 № 2/02
танай ____________ -ны № ____________ -т

ҮЕНЧ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦОГОО ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Үенч сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан, Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үенч сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, заавраар дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,261,650.50** | **42,229,202.00** |
| **33** | **АВЛАГА** | 55,044,251.00 | 22,688,773.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 42,284,451.00 | 6,705,073.00 |
| **335** | **Бусад авлага** | 12,759,800.00 | 15,983,700.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 12,759,800.00 | 15,983,700.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 23,217,399.50 | 19,540,429.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 657,500.00 | 657,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 657,500.00 | 657,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 22,559,899.50 | 18,882,929.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,760,929.50 | 4,760,929.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,114,470.00 | 867,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,200,000.00 | 2,420,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,484,500.00 | 10,834,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **909,441,658.08** | **1,304,297,339.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 909,441,658.08 | 1,304,297,339.90 |
| **392** | **Биет хөрөнгө** | 897,173,658.08 | 1,292,029,339.90 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 673,050,584.25 | 1,111,180,500.25 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -101,376,879.24 | -132,915,163.71 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 237,235,795.00 | 238,959,995.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -148,800,798.75 | -149,791,664.07 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 161,999,260.00 | 173,856,403.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -119,995,075.33 | -133,211,645.68 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 94,075,804.00 | 94,075,804.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -62,270,413.16 | -67,456,028.24 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,345,173,910.00 | 2,345,173,910.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -2,345,173,910.00 | -2,345,173,910.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 120,484,837.00 | 120,484,837.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -71,162,788.69 | -77,087,030.65 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 113,933,333.00 | 113,933,333.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12,268,000.00 | 12,268,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,631,500.00 | 13,631,500.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,363,500.00 | -1,363,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **987,703,308.58** | **1,346,526,541.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,368,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,368,000.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 1,368,000.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,368,000.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,368,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **986,335,308.58** | **1,346,526,541.90** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 986,335,308.58 | 1,346,526,541.90 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,609,346,627.00 | 1,609,346,627.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,609,346,627.00 | 1,609,346,627.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -786,762,547.56 | -426,571,314.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -786,762,547.56 | -786,762,547.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 360,191,233.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 163,751,229.14 | 163,751,229.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **987,703,308.58** | **1,346,526,541.90** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **516,305,418.00** | **934,089,954.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **55,425,000.00** | **444,254,283.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 55,425,000.00 | 444,254,283.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 55,425,000.00 | 444,254,283.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 840,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 54,585,000.00 | 444,254,283.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **460,880,418.00** | **489,835,671.01** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 101,171,418.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 101,171,418.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 77,067,271.01 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 54,731,271.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 22,336,000.01 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 359,709,000.00 | 412,768,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 340,954,600.00 | 403,228,400.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 18,754,400.00 | 9,540,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 18,754,400.00 | 9,540,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **529,801,024.48** | **571,298,167.61** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **529,801,024.48** | **571,298,167.61** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 516,558,724.48 | 550,606,567.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 199,750,069.00 | 247,909,520.90 |
| 210101 | Үндсэн цалин | 199,750,069.00 | 247,909,520.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,928,054.00 | 30,963,657.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,928,054.00 | 30,963,657.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,202,695.09 | 35,161,403.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,233,200.00 | 3,443,103.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,969,495.09 | 31,718,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,368,983.22 | 25,875,897.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,356,960.00 | 3,286,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,740,800.00 | 19,024,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,271,223.22 | 3,564,597.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 402,000.00 | 402,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 402,000.00 | 402,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,582,050.00 | 850,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 250,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,382,050.00 | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,496,300.00 | 3,556,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 8,496,300.00 | 3,556,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,614,400.00 | 16,362,961.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,664,400.00 | 15,943,461.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000.00 | 160,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 275,000.00 | 200,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 247,000.00 | 29,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 194,214,173.17 | 189,524,328.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 82,084,784.28 | 89,426,604.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 112,129,388.89 | 100,097,724.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,242,300.00 | 20,691,600.01 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 247,500.00 | 275,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 247,500.00 | 275,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,994,800.00 | 20,416,600.01 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,994,800.00 | 20,416,600.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-13,495,606.48** | **362,791,786.40** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,921,801.50 | 2,600,553.08 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,921,801.50 | 2,600,553.08 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,921,801.50 | -2,600,553.08 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-15,417,407.98** | **360,191,233.32** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **461,720,418.00** | **489,835,671.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **840,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 840,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 840,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 840,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **460,880,418.00** | **489,835,671.01** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 101,171,418.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 101,171,418.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 77,067,271.01 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 54,731,271.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 22,336,000.01 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 359,709,000.00 | 412,768,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 340,954,600.00 | 403,228,400.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 18,754,400.00 | 9,540,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **461,720,418.00** | **489,835,671.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **461,720,418.00** | **489,835,671.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **448,450,618.00** | **469,144,071.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 204,499,462.00 | 243,694,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 142,397,588.00 | 155,918,436.15 |
| 210102 | Нэмэгдэл | 28,384,674.00 | 47,156,763.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,717,200.00 | 40,619,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,598,138.00 | 32,899,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,415,438.00 | 23,151,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,045,700.00 | 2,437,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,636,600.00 | 1,949,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 409,100.00 | 487,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,091,300.00 | 4,874,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,254,300.00 | 30,625,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,442,200.00 | 3,687,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,812,100.00 | 26,938,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,383,700.00 | 25,667,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,199,000.00 | 3,199,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,740,800.00 | 19,024,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,443,900.00 | 3,443,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 402,000.00 | 402,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 402,000.00 | 402,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,342,700.00 | 800,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,142,700.00 | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,496,300.00 | 3,556,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,496,300.00 | 3,556,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,334,400.00 | 17,806,791.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,384,400.00 | 16,619,791.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000.00 | 260,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 275,000.00 | 275,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 30,000.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 247,000.00 | 475,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,000.00 | 147,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 119,139,618.00 | 113,691,880.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 119,139,618.00 | 113,691,880.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,269,800.00** | **20,691,600.01** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 275,000.00 | 275,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 275,000.00 | 275,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 12,994,800.00 | 20,416,600.01 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,994,800.00 | 20,416,600.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,597,828,627.00 | 4,894,833.00 | -1,006,020,407.90 | 596,703,052.10 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,597,828,627.00** | **4,894,833.00** | **-1,006,020,407.90** | 596,703,052.10 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 230,977,444.52 | 230,977,444.52 |
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,609,346,627.00** | **163,751,229.14** | **-786,762,547.56** | 986,335,308.58 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,609,346,627.00** | **163,751,229.14** | **-786,762,547.56** | 986,335,308.58 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,609,346,627.00** | **163,751,229.14** | **-786,762,547.56** | 986,335,308.58 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 360,191,233.32 | 360,191,233.32 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,609,346,627.00** | **163,751,229.14** | **-426,571,314.24** | 1,346,526,541.90 |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 417,106,000.00 | 408,335,500.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 417,106,000.00 | 408,335,500.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 416,831,000.00 | 408,060,500.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 243,694,800.00 | 243,694,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 158,086,900.00 | 155,918,436.15 |
| 210102 | Нэмэгдэл | 44,988,300.00 | 47,156,763.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 40,619,600.00 | 40,619,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,899,000.00 | 32,899,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,151,100.00 | 23,151,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,437,000.00 | 2,437,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,949,500.00 | 1,949,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 487,400.00 | 487,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,874,000.00 | 4,874,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,625,500.00 | 30,625,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,687,200.00 | 3,687,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,938,300.00 | 26,938,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,167,800.00 | 25,667,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,199,000.00 | 3,199,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,524,900.00 | 19,024,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,443,900.00 | 3,443,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 402,000.00 | 402,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 402,000.00 | 402,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,540,500.00 | 800,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,340,500.00 | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,539,900.00 | 3,556,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,539,900.00 | 3,556,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,132,000.00 | 14,176,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,945,000.00 | 12,989,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 260,000.00 | 260,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 275,000.00 | 275,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 475,000.00 | 475,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 147,000.00 | 147,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,829,500.00 | 56,238,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,829,500.00 | 56,238,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 275000.00 | 275000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 275,000.00 | 275,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 275,000.00 | 275,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 417,106,000.00 | 408,335,500.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 416,501,000.00 | 408,335,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 406,961,000.00 | 398,795,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 9,540,000.00 | 9,540,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 605,000.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605,000.00 | 00.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 00.00 | 00.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 00.00 | 00.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0 | 0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 28 | 29 |
| 620001 | Удирдах ажилтан | 8 | 8 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15 | 15 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 3 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3 | 3 |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,851,230.00** | **61,083,571.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,851,230.00** | **61,083,571.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **27,851,230.00** | **61,083,571.01** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 3,629,891.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3,629,891.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 57453680.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,851,230.00 | 57,453,680.01 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | **27,851,230.00** | **61,083,571.01** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,851,230.00 | 54,731,271.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 6,352,300.01 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

# 3.АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Үенч сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Б.Цогоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч төсвийн хөрөнгийн зарцуулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-ноос 2021 оны 01 дугаар сарын 25–ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ЗДТГ нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Тухайн шатны хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

## 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Үенч сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг 2018, 2019 оны үйл ажиллагаанд хяналт хийгдэж нийт 6654.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 355.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, мянган төгрөгийн зөрчилд 6297.7 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн 355.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 6297.7 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэн ажилсан байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар орлогын гүйлгээг мэдээлээгүй байгааг мэдээлж ажиллах зөвлөмжийг өгсөн байна.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 459354.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4593.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 934089.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9340.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үенч сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 358.8 мянган төгрөгөөр буюу 36 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| Авлага | 55,044.25 | 22,688.77 | -32,355.48 | -59% |
| Бараа материал | 23,217.40 | 19,540.42 | -3,676.98 | -16% |
| Үндсэн хөрөнгө | 909,441.66 | 1,304,297.34 | 394,855.68 | 43% |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **987,703.31** | **1,346,526.53** | **358,823.22** | **36%** |
| **Богино хугацаат өр төлбөр** | **1368** | **0.00** | -1,368.00 | **-100%** |
| Цэвэр хөрөнгө, өмч | 986,335.31 | 1,346,526.54 | 360,191.23 | 37% |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **987,703.31** | **1,346,526.54** | 358,823.23 | **36%** |

Авлага дансны үлдэгдэл 22688.8 мянган төгрөг болж 32355.5 мянган төгрөгөөр буурсан нь 2018 онд үүссэн 35000.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон авлагыг хуулийн байгууллагад шилжүүлэн тээврийн хэрэгсэл хүлээн авсан, нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 12823.8 мянган төгрөгийн авлага буцаж дансанд орж ирж бусад 215.3 мянган төгрөгийн авлага барагдаж нийт 48039.1 мянган төгрөгийн авлага бууруулжээ.

2020 оны эцэст нэмэлт данснаас төвлөрүүлсэн 13983.7 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн, цалингийн урьдчилгаа болон төлбөрийн актыг цалингаас суутгахгүйгээр төлсөнтэй холбоотойгоор 1.7 сая нийт 13984.5 сая төгрөгийн авлага нэмэгдсэн байна. Авлага дансны үлдэгдэлд 2011 онуудад үүссэн, он удаан жил болсон мянган төгрөгийн хувь хүнээс үүссэн 4982.1 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19540.4 мянган төгрөг болж 3676.98 мянган төгрөгөөр буурсан нь тайланд оны 11 сард төвлөрсөн дулаантай холбогдсоноор нүүрсний нөөц татаж аваагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 909441.7 мянган төгрөг, оны эцэст 1304297.3 мянган төгрөгөөр болж 394855.7 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтаар 398991.8 мянган төгрөгөөр услалтын систем, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 42554.9 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар гүүр барихад 9149.7 мянган төгрөг, аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсээс 1857.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авч хөрөнгө нэмэгдсэн байна. Мөн 2018 онд үүссэн авлагаас 35000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэн авсан байна.

Аймгийн ИТХ-ын 105 тоот, 115 тоот тогтоолоор 10 нэр төрлийн 11975.8 мянган төгрөгийн акталсан, дуудлага худалдаагаар 3 нэр төрлийн 33866.9 зарж борлуулан 45842.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Өр төлбөр оны эхэнд 1368.0 мянган төгрөг байсныг тайлант онд бүрэн барагдуулан ажиллаж оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1346526.5 мянган төгрөг болж тайлант онд 360191.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Үенч сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 417784.5 мянган төгрөгөөр буюу 55.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 417784.5 мянган төгрөгийн орлогоос 53059.4 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 389669.3 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 41497.2 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 48159.4 мянган төгрөг буюу 19.4 хувиар, тогтмол зардал 4957.8 мянган төгрөг буюу 14.1 хувиар, бусад урсгал шилжүүлэг 7421.8 мянган төгрөг буюу 36.4 хувиар өссөн, хангамж бараа материалын зардал 6493.0 мянган төгрөг буюу 25.1 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 2732.1 мянган төгрөг буюу 321.4 хувиар, томилолтын зардал 4940.0 мянган төгрөг буюу 139 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 426640.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 426640.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 12/02 тоот тогтоолоор ЗДТГ-ын 2020 оны төсвийг 417106.0 мянган төгрөгөөр баталжээ.

### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 417106.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 406961.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 9540.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 403228.4 мянган төгрөг, ОНХС-аас 9540.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 4127ыыы68.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 408335.5 мянган төгрөгийг зарцуулж 4332.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 408335.5 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 3500.0 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 740.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 955.1 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 2983.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 591.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 2020.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал, хог хаягдал орчны бохирдлын арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт /мян.төг/

| код | хөтөлбөр, арга хэмжээ | мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 7224.1 |
| 80106 | Баг хорооны үйл ажиллагааны зардал | 468.4 |
| 81102 | Бараа үйлчилгээний бусад зардал | 591.3 |
| 80205 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 95.0 |
| 82212 | Хур хог хаягдал орчны бохирдол | 125.0 |
| 80103 | Ахмад настны хөгжил хамгаалал | 266.7 |
| | ДҮН | 8770.5 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн хөрөнгө оруулалтаар Улиаст багийн Хүрэмтийн амны гүүр, далан барих 16149.7, Хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж барих 15000.0, мөн цэцэрлэгийн хүүхдийн тоглоом нийлүүлэх 14128.4, статистикийн хэлтсээс судалгааны ажлын зардалд 3479.9 аймгийн Онцгой байдлын газраас 120.0, Ковид-19 цар тахлын санхүүжилт 875,7 ХХҮГ-аас ахмадын баярын санхүүжилт 2000.0, хүү торгуулийн орлого 6210.0 аймгийн хөрөнгө оруулалтын данснаас 2177.6 сумын орон нутгийн хөгжлийн санхүүжилтээс 1368.0 оны эхний үлдэгдлээс 12759.8 барьцаа дэнчин дуудлага худалдааны орлогоос 3997,3 мянган төгрөг нийт 81064,4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс орон сууц хүн амын тооллого, хагас жилийн мал тооллогын судалгааны зардалд 3479.9 мянган, Улиаст багийн Хүрэмтийн амны гүүр, далан барих 16149.7 мянган төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж барих 15000.0, ахмадын баярын үйл ажиллагааны зардал 2000.0 мянган төгрөг, хууль бусаар ан агнасан мэдээлэгчийн зардалд 6210.0 Жаргалан багийн ванны үлдэгдэл санхүүжилт 1368.0, Үенчийн ирээдүй хоршооны барьцааны 2177.6 мянган төгрөг, онцгой нөхцөлд ажилласан ажилчдын урамшуулал 120.0 мөн цэцэрлэгийн хүүхдийн тоглоом нийлүүлэх 14128.4, , Цагаан түнгэ

багийн аймгийн аварга багаар шалгарсан 300.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 15983,7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 159 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 29 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 498.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 23990.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна. Харин 4982.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь сумын ЗДТГ-ын нягтлан бодогчоор ажиллаж байсан хувь хүнтэй холбоотой авлагыг барагдуулан ажиллах зөвлөмж өгөгдсөнөөс тус иргэн нь тухайн суманд амьдардаггүйтэй холбоотой байна. Тус иргэнийг 2021 онд хуулийн байгууллагад шилжүүлэхээр ЗДТГ-ын даргатай холбогдож тайлбарыг авсан.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 498 | 1 | 498 | 0 | 0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 23990.8 | 1 | 23990.8 | 0 | 0 | 100 |
| Зөвлөмж | 1 | 4982.1 | 0 | 0 | 1 | 4982.1 | 0 |
| **Нийт дүн** | **3** | **29470.9** | **2** | **24488.8** | **1** | **4982.1** | **66.7** |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7217.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 519.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 6700 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн 6700.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломтой хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Авлагын бүртгэл

1.1. *Илрүүлэлт:* Байгууллагын санхүүгийн тайланд олон жил болсон 4982.1 мянган төгрөгийн авлага болон тайлант онд ажлаас халагдсан хувь хүмүүстэй холбоотой 1700.0 мянган төгрөгийн авлага байна.

*Эрсдэл:* Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, авлага төлөгдөхгүй удсанаас төлөгдөх найдвар багасаж төсвийн хөрөнгийг буцаан авч чадахгүйд хүрэх

1.2. *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг мөрдөн ажиллаж тухайн байгууллагад ажиллахгүй байгаа хувь хүмүүстэй холбоотой авлагыг хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэн ажиллах*

1.3. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

### 2. Байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлын зарцуулалт

2.1. *Илрүүлэлт:* Тайлант онд Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг зарцуулах эрх нь Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд байдаг ч ЗДТГ-ын даргын А/15, А16, А24 тоот тушаалаар байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна
*Эрсдэл:* Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

2.2. *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд захирамж гаргуулан байгаль хамгаалан сангийн хөрөнгийг зарцуулж хэвших*

2.3. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | ***Үенч сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: ХОА-2021/46/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Үенч сумын Засаг даргын тамгын газар** | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | МЭУСАХ-ны зардлыг илүү санхүүжүүлсэн. | 517.6 | Төлбөрийн акт | Тамгын газрын дарга , нягтлан бодогч | Х.Соёлмаа Х.Отгонням |
| 2 | Тус байгууллагад ажилладаггүй ажлаас гарсан хувь хүмүүстэй холбоотой авлагыг бууруулан ажиллаагүй | 6700.0 | Зөвлөмж өгөх | | |
| 3 | Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийг зөрчин Төсвийн төвлөрүүлэн захирагчийн захирамж гаргуулахгүйгээр ЗДТГ-ын даргын тушаалаар зарцуулсан | 00 | Зөвлөмж өгөх | | |
| **ДҮН** | | **7217.6** | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**